

**2020 оны Монгол Улсын Орхон
Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын сонгуульд бие даан нэр
дэвшигч Нэргүй овогтой
Наранмандахын Мөрийн хөтөлбөр**

Нэр _____
Гарын үсэг _____

Н. Наранмандах

Н.Наранмандах миний бие Орхон аймгийн ИТХ-н сонгуульд бие даан нэрээ дэвшүүлэх хүсэлтээ илэрхийлж, холбогдох хууль, дүрэм, журманд заасны дагуу 3 уриа, бодлогын шинэчлэлтийн хүрээнд, 4 үндсэн чиглэлээр өөрийн мөрийн хөтөлбөрөө боловсруулсан. Мөрийн хөтөлбөрийг боловсруулахдаа Монгол улсын үндсэн хууль, Аймаг, Нийслэл, Сум, Дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын хууль, "Алсын хараа -2050" зэрэг хууль тогтоомж, баримт бичгийг удирдлага болгон боловсрууллаа.

Уриа:

1. НЭГДЬЕ!

Нам, эвсэл, нутаг ус, шашин шүтлэг хамаарахгүй Эрдэнэт хотынхоо хөгжлийн төлөө гэсэн нэгдмэл үзэл баримтлалыг бий болгоё.

2. ОРОЛЦОЁ!

Бидний оролцоогүй ӨНӨӨДӨР, бидний хүсээгүй МАРГААШИЙГ бүтээж байна.


3. ӨӨРЧИЛЬЕ!

Эсвэл энэ хэвээрээ үлдье.

Тууштай баримтлах бодлого:

1. Хүртээмжтэй,
2. Оролцоотой,
3. Тогтвортой өсөлтийг хангах.

Нэр Н.Наранмандах
Гарын үсэг _____



Иргэдийн оролцоотой хот:

1. Аюулгүй орчинтой, унаган төрхтэй байгалийг хойч үедээ хэвээр өвлүүлэх бодлогыг хэрэгжүүлэх
2. “Хотын хөгжил Хорооллоос” төсөл хөтөлбөрийг боловсруулан хувийн болон нийтийн эзэмшлийн гудамж талбайг Аймгийн ЗДТГ болон иргэдийн санал асуулга, санаачилгаар цэцэрлэгжүүлэх ногоон байгууламжийг бий болгон тохижуулах.
3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгэмд оролцох байр суурийг нь сайжруулан нийгэмшүүлэх, төлөвшүүлэхэд, бие даан амьдрахад нь дадал олгох нэгдсэн төв байгуулахад нь бодлогоор дэмжинэ. (Эрүүл мэндийн дасгал сургуулалт хийх, спорт, урлагийн зарим нэг төрлөөр хичээллэх, суурь боловсрол эзэмшихэд нь туслах, ажиллах хөдөлмөрлөхөд нь дадал олгох)
4. Орон сууц, ногоон байгууламжийн стандартыг мөрдөж, эрүүл баталгаат амьдрах орчныг бий болгох хүүхдийн амьдрах, тоглох эрүүл аюулгүй орчинг бүрдүүлэх.
5. Хот төлөвлөлт, хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалт болон олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаа бүрт төлөвлөлтөөс нь эхлээд үр дүн гарах хүртлэх үйл явцад иргэдийн оролцоог хангах
6. Салбар хоорондын тэнцэл дээр тулгуурлан орон нутгийн төсвийн зарцуулалт, төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх, хийгдэж буй ажил үйлчилгээнд хяналт, үнэлгээ хийхэд олон нийтийн болон ТББ-уудын ОРОЛЦООГ хангаж, сайжруулах механизмыг нэвтрүүлэх

Бизнес таатай хот:

1. Бизнесийн шударга өрсөлдөөн, тэгш боломжтой байдлыг хангах замаар хамгийн таатай орчныг бүрдүүлэх
2. НҮСЭР төрөөс ТӨСӨР төр байх, төрийн бүх үйлчилгээг цахимжуулах, төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчим дээр тулгуурлан хэрэгжүүлэх
3. Өөрөө өөртөө ажлын байр бий болгох санаачлагыг дэмжих, дундаж давхаргыг тэгш боломж олгох нөхцлийг бүрдүүлэх
4. Аймгийн хэмжээнд батлагдсан болон хэрэгжиж буй бодлогыг үргэлжлүүлэн үр дүнг гаргах

Оюунлаг залуусын хот:

1. Бүтээлч аж үйлдвэрлэлийн салбар болон мэдээлэл технологийн гарааны бизнесийн эко системийг бүрдүүлэх
2. “Англи хэлтэй хот” хөтөлбөрийг аймгийн ЗДТГ, Боловсрол соёлын газар болон бусад сургалтын байгууллагуудтай хамтран зохион байгуулах
3. Эрдэнэт хотоос гадаадад амжилттай ажиллаж суралцаж байгаа залуучуудын нөөцийг хотын хөгжилд ашиглах платформыг зохион байгуулах

Эрдэнэт 20/30/40:

1. Сайн засаглал, ил тод, улс төрөөс ангид, хариуцлагатай уул уурхайн зарчмыг бүрэн нутагшуулах
2. Хангайн бүсийн төвийн хувьд бүсийн давуу тал, нөөцөд тулгуурласан боловсруулах үйлдвэрлэлийн кластерийг хөгжүүлэх нөхцлийг бүрдүүлэх

Нэр _____
Гарын үсэг _____